
Төв аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

Улсын төсвөөс олгосон сонгууль зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан байна.



**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГИЙН СОНГУУЛИЙН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

2017 ОН

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Төв аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал	Асуудал 1
Аудитын менежер О.Амаржаргал	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс Төв аймагт эхний санал хураалтад 379193.4 мянган төгрөг, хоёрдох санал хураалтад 136085.0 мянган төгрөг хувиарласан байна. 5-10
Ахлах аудитор Л.Жаргалсайхан	Асуудал 2
Аудитор Ц.Саранчимэг	Аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтыг хүлээж авахдаа акт үйлдээгүй байна.10-12
О.Сосор	
2017 оны 8 дугаар сарын 08-ны өдөр	Дүгнэлт 13
Уг тайланг audit.mn веб сайт-аас үзнэ үү.	Зөвлөмж 14
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70273204 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу	Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал ... 15 Саналд өгсөн тайлбар
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын 2-р ордон	

Товчилсон үгийн тайлбар

ҮАГ	Үндэсний Аудитын Газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ССХ	Сумын сонгуулийн хороо
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилж, зарцуулсан эсэх
2. Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх

Аудитад аймгийн Сонгуулийн хороо болон сумдын хэсгийн хороодын санхүүгийн баримт материал, цагийн бүртгэл, урамшуулал хоол унааны мөнгө олголт, батлагдсан төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл, бараа материалын тайлангууд, сонгуулийн хороо болон хэсгийн хороодын даргын захирамжууд зэрэг материалууд хамрагдсан болно.

Сумдын Сонгуулийн хороодын санхүүгийн баримт болон зарцуулалтын тайлангуудыг 2017 оны 7-р сарын 26-наас 2017 оны 8-р сарын 4-ны хооронд Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгадагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, харьцуулах, дүн шинжилгээ хийх, түүвэрлэлт хийх болон аудитын бусад горим, арга зүйг ажиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.15;
- ✓ МУ-ын 2017 оны төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл;
- ✓ Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 23 дугаар зүйлийн 23.2, 31 дүгээр зүйлийн 31.7, 31.8, 31.9, 31.10, 31.11, 31.15, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6, 33 дугаар зүйлийн 33.13, 34 дүгээр зүйлийн 34.1.1, 34.1.6, 36 дугаар зүйлийн 36.7, 38 дугаар зүйлийн 38.2;
- ✓ Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5, 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.4, 13.1.5, 13.3;
- ✓ СЕХ-ны 2016 оны 4 дүгээр тогтоол;
- ✓ СЕХорооноос батлан гаргасан бусад дүрэм, журам, заавар;
- ✓ Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Ахлах аудитор Л.Жаргалсайхан удирдан, аудитор Ц.Саранчимэг, О.Сосор нар 2017 оны 7-р сарын 26-ноос 8-р сарын 8-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардалын гүйцэтгэл

Асуудал 1

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс Төв аймагт эхний санал хураалтад 379193.4 мянган төгрөг, хоёрдох санал хураалтад 136085.0 мянган төгрөг хувиарласан байна.

1.1 Сонгуулийн Ерөнхий Хороо нь сонгуулийн батлагдсан төсвийг зохих эдийн засгийн ангилалын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан төлөвлөсөн эсэх.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардалыг баталсан.

Сонгуулийн Ерөнхий Хороо нь Сонгуулийн тухай хууль тогтоомж, СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын дагуу аймгийн Сонгуулийн хороонд сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлыг улсын төсвөөс хувиарласан байна.

Төв аймаг 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 92.8 мянган хүн амтай үүнээс сонгуулийн эрх бүхий 61758 иргэн байгаагаас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн сонгогчийн нэрсийн жагсаалтад 61158 иргэн бүртгэгдсэн байна. Мөн түүнчлэн улсын хэмжээнд хамгийн олон буюу 27 сумтай, аймгийн хэмжээнд 84 сонгуулийн хэсэг байгуулагдан сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулжээ. Аймгийн сонгуулийн хороонд 9, сумдын сонгуулийн хороонд 137 гишүүн, санал авах байрны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч, даамал 665, нийт 802 хүн ажилласан байна.

Сонгуулийн Ерөнхий Хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангилалын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан хувиарлажээ.

д/д	огноо	Төсөв хувиарласан албан тоот	Төсөв /төг/
1	2017.04.26	СЕХ-ны 113 тоот албан бичиг 2 дугаар хавсралт	48960000
2	2017.05.30	СЕХ-ны 172 тоот албан бичиг 2 дугаар хавсралт	83615000
3	2017.06.13	СЕХ-ны 199 тоот албан бичиг 2 дугаар хавсралт	36918000
4	2017.06.21	СЕХ-ны 210 тоот албан бичиг 2 дугаар хавсралт	209139600
5	2017.06.28		560800
	дүн		379193400

СЕХ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад улсын төсвөөс 379193.4 мянган төгрөгийг Төв аймагт хувиарласан байна. Энэхүү хувиарласан төсвөөр 2017 оны 6 дугаар сарын 26-нд болсон эхний шатны санал хураалтыг зохион байгуулжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу анхан шатны санал хураалтаар нэр дэвшигчийн хэн ч олонхийн санал аваагүй тул хоёр дахь санал хураалт явуулах болж Засгийн газрын шийдвэрээр ЗГ-ын нөөц сангаас 7.2 тэрбум зарцуулахаар шийдвэрлэсэн.

Хоёрдох шатны санал хураалтад Төв аймагт 136085.0 мянган төгрөг хувиарласан байна.

д/д	огноо	Төсөв хувиарласан албан тоот	Төсөв /төг/
1	2017.07.03	СЕХ-ны 260 тоот албан бичиг 2 дугаар хавсралт	54085000
2	2017.05.30	СЕХ-ны 172 тоот албан бичиг 2 дугаар хавсралт	82000000
	дүн		136085000

СЕХ нь АСХ-нд сонгууль зохион байгуулах зардал, төсвийн хуваарь хийхдээ орон нутгаас ямар нэг байдлаар санал авдаггүй, аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан хувиарлаж байна.

1.2. Төсвөөс олгох хөрөнгийг сонгуулийн хороодод холбогдох журмын дагуу хуваарилсан эсэх

Аймгийн сонгуулийн хороо СЕХ-с хувиарласан эхний шатны санал хураалтын төсвийг дараахь байдлаар хувиарласан байна.

д/д	Сумын нэр	Дүн	Сумдын сонгуулийн хорооны зардал						/мян.төг/
			Шуудан холбоо	Бичиг хэрэг	Унааны зардал	Санал авах байр бэлтгэх	Сурталчлалгааны материал хүргэх зардал	Урамшуулал хоолны зардал	
1	Алтанбулаг	14046,8	870,0	920,0	1600,0	800,0	300,0	9556,8	
2	Аргалант	5346,0	330,0	380,0	700,0	200,0	100,0	3636,0	
3	Архуст	7011,6	510,0	560,0	800,0	400,0	100,0	4641,6	
4	Батсүмбэр	14046,8	870,0	920,0	1600,0	800,0	300,0	9556,8	
5	Баян	10245,2	690,0	740,0	1300,0	600,0	300,0	6615,2	
6	Баяндэлгэр	8379,6	510,0	560,0	1100,0	400,0	200,0	5609,6	
7	Баянжаргалан	9716,2	690,0	740,0	1300,0	600,0	255,0	6131,2	
8	Баян-Өнжүүл	8519,6	510,0	560,0	1200,0	400,0	240,0	5609,6	
9	Баянхангай	5346,0	330,0	380,0	700,0	200,0	100,0	3636,0	
10	Баянцагаан	14610,4	1050,0	1100,0	1900,0	1000,0	450,0	9110,4	
11	Баянцогт	10195,2	690,0	740,0	1300,0	600,0	250,0	6615,2	
12	Баянчандмань	10863,2	690,0	740,0	1000,0	600,0	250,0	7583,2	
13	Борнуур	13896,8	870,0	920,0	1400,0	800,0	350,0	9556,8	
14	Бүрэн	14146,8	870,0	920,0	1600,0	800,0	400,0	9556,8	
15	Дэлгэрхаан	11213,2	690,0	740,0	1300,0	600,0	300,0	7583,2	
16	Жаргалант	14146,8	870,0	920,0	1600,0	800,0	400,0	9556,8	
17	Заамар	14346,8	870,0	920,0	1800,0	800,0	400,0	9556,8	
18	Зуунмод	22458,4	1410,0	1460,0	1800,0	1400,0	350,0	16038,4	

19	Лүн	8279,6	510,0	560,0	1000,0	400,0	200,0	5609,6
20	Мөнгөнморьт	8479,6	510,0	560,0	1200,0	400,0	200,0	5609,6
21	Өндөрширээт	8279,6	510,0	560,0	1000,0	400,0	200,0	5609,6
22	Сүмбэр	5346,0	330,0	380,0	700,0	200,0	100,0	3636,0
23	Сэргэлэн	16980,4	1050,0	1100,0	1900,0	1000,0	400,0	11530,4
24	Угтаал	7795,6	510,0	560,0	1000,0	400,0	200,0	5125,6
25	Цээл	7341,6	510,0	560,0	1000,0	400,0	230,0	4641,6
26	Эрдэнэ	19964,0	1230,0	1280,0	2300,0	1200,0	450,0	13504,0
27	Эрдэнэсант	11463,2	690,0	740,0	1500,0	600,0	350,0	7583,2
	Сумдын СХ-ны дүн	302465,0	19170,0	20520,0	35600,0	16800,0	7375,0	203000,0
	Аймгийн СХ	76728,4						
	Нийт дүн	379193,4						

Сумдын СХ-нд хувиарласан 302465.0 мянган төгрөгөөс шуудан холбооны зардалд 19170.0 мянган төгрөг буюу 6.3 хувь, бичиг хэргийн зардалд 20520.0 мянган төгрөг буюу 6.8 хувь, унааны зардалд 35600.0 мянган төгрөг буюу 11.8 хувь, санал авах байр бэлтгэх зардалд 16800.0 мянган төгрөг буюу 5.6 хувь, сурталчилгааны материал хүргэх зардалд 7375.0 мянган төгрөг буюу 2.4 хувь, сонгуулийн хороо, хэсэгт ажилласан хүмүүсийн урамшуулал, хоолны зардалд 203000.0 мянган төгрөг буюу 67.1 хувийг зарцуулахаар хувиарласан байна.

Аймгийн сонгуулийн хороо хоёрдох шатны санал хураалтын төсвийг дараахь байдлаар хувиарласан байна

д/д	Сумын нэр	Дүн	Сумдын сонгуулийн хорооны зардал						
			Бичиг хэрэг	Шуудан холбоо	Унааны зардал	Хоол	Урамшуулал	Эрчим хүчний эх үүсвэр	Мэдээ дамжуулах зардал
1	Алтанбулаг	5339,0	80,0	100,0	225,0	760,0	3800,0	168,0	206,0
2	Аргалант	1924,0	35,0	40,0	75,0	280,0	1400,0	42,0	52,0
3	Архуст	2582,0	50,0	60,0	125,0	360,0	1800,0	84,0	103,0
4	Батсүмбэр	5339,0	80,0	100,0	225,0	760,0	3800,0	168,0	206,0
5	Баян	3766,0	65,0	80,0	175,0	520,0	2600,0	126,0	200,0
6	Баяндэлгэр	3062,0	50,0	60,0	125,0	440,0	2200,0	84,0	103,0
7	Баянжаргалан	3480,0	65,0	80,0	175,0	480,0	2400,0	126,0	154,0
8	Баян-Өнжүүл	3062,0	50,0	60,0	125,0	440,0	2200,0	84,0	103,0
9	Баянхангай	1924,0	35,0	40,0	75,0	280,0	1400,0	42,0	52,0
10	Баянцагаан	5277,0	95,0	120,0	275,0	720,0	3600,0	210,0	257,0
11	Баянцогт	3720,0	65,0	80,0	175,0	520,0	2600,0	126,0	154,0
12	Баянчандмань	4200,0	65,0	80,0	175,0	600,0	3000,0	126,0	154,0
13	Борнуур	5339,0	80,0	100,0	225,0	760,0	3800,0	168,0	206,0

14	Бүрэн	5339,0	80,0	100,0	225,0	760,0	3800,0	168,0	206,0
15	Дэлгэрхаан	4200,0	65,0	80,0	175,0	600,0	3000,0	126,0	154,0
16	Жаргалант	5433,0	80,0	100,0	225,0	760,0	3800,0	168,0	300,0
17	Заамар	5433,0	80,0	100,0	225,0	760,0	3800,0	168,0	300,0
18	Зуунмод	8761,0	125,0	160,0	375,0	1280,0	6400,0	294,0	127,0
19	Лүн	3062,0	50,0	60,0	125,0	440,0	2200,0	84,0	103,0
20	Мөнгөнморьт	3062,0	50,0	60,0	125,0	440,0	2200,0	84,0	103,0
21	Өндөрширээт	3062,0	50,0	60,0	125,0	440,0	2200,0	84,0	103,0
22	Сүмбэр	1924,0	35,0	40,0	75,0	280,0	1400,0	42,0	52,0
23	Сэргэлэн	6477,0	95,0	120,0	275,0	920,0	4600,0	210,0	257,0
24	Угтаал	2822,0	50,0	60,0	125,0	400,0	2000,0	84,0	103,0
25	Цээл	2582,0	50,0	60,0	125,0	360,0	1800,0	84,0	103,0
26	Эрдэнэ	7617,0	110,0	140,0	325,0	1080,0	5400,0	252,0	310,0
27	Эрдэнэсант	4200,0	65,0	80,0	175,0	600,0	3000,0	126,0	154,0
	Сумдын СХ-ны дүн	112988,0	1800,0	2220,0	4875,0	16040,0	80200,0	3528,0	4325,0
	Аймгийн СХ	23097,0							
	Нийт дүн	136085,0							

Сумдын СХ-нд хувиарласан 112988.0 мянган төгрөгөөс шуудан холбооны зардалд 2220.0 мянган төгрөг буюу 2 хувь, бичиг хэргийн зардалд 1800.0 мянган төгрөг буюу 1.6 хувь, унааны зардалд 4872.0 мянган төгрөг буюу 4.3 хувь, хоолны зардалд 16040.0 мянган төгрөг буюу 14.2 хувь, урамшуулалд 80200.0 мянган төгрөг буюу 71.0 хувь, Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэхэд 3528.0 мянган төгрөг буюу 3.1 хувь, Мэдээ дамжуулах зардалд 4325.0 мянган төгрөг буюу 3.8 хувийг тус тус зарцуулахаар хувиарласан байна.

Сумдад хувиарласан зардлын дийлэнхийг буюу 67.1-85.2 хувийг сонгуулийн хороо, хэсэгт ажилласан хүмүүсийн урамшуулал, хоолны зардалд хувиарласан байна.

АСХороо нь ССХ-нд төсөв зардал хувиарлахдаа СЕХ-оос ирсэн албан тоотууд түүний хавсралт төсөв хувиарласан тайлбарт заасан чиглэл, зөвлөмжүүдийг баримтлан ажилласан байна.

1.3 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулсан эсэх.

СЕХ-оос эхний шатны санал хураалтад хувиарласан 379193.4 мянган төгрөгийг 3-н удаагийн санхүүжилтээр ирүүлжээ. Үүнээс 360285.6 мянган төгрөгийг зарцуулж 18907.8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хоёрдох шатны санал хураалтаар 136085.0 мянган төгрөг хувиарлаж 2 удаа санхүүжилт хийсэн байна. 128123.4 мянган төгрөг зарцуулж 7961.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

АСХ нь улсын төсвөөс хувиарласан сонгууль зохион байгуулах төсвийг СЕХ-с ирүүлсэн албан тоот түүний хавсралт төсөв хувиарласан тайлбараар өгсөн чиглэл зааврын дагуу зарцуулсан байна. Сонгуулийн хороо, хэсэгт ажилласан хүмүүсийн урамшуулал, зарим иргэнээс авсан бараа, ажил үйлчилгээний зардлаас ХХОАТ-ыг суутган татварын дансанд төвлөрүүлсэн байна.

АСХ, ССХороод нь хувиарлагдсан төсвөөс автомашины аккумулятор, дугуй, амартизор, салхины шил, уртасгагч, ус буцалгагч, бичгийн тавиур, тооны машин, галын хор, флаш диск, прожектор, зөөврийн гэрэл, гар чийдэн, баримт үдэгч, үдээсний машин, хулдаас, абжур, самбар, галын хор, хогийн сав гэх мэт дахин ашиглах боломжтой эд зүйлсийг худалдан авсан байна.

Худалдан авсан зүйлсийн дүн

д/д	Сонгуулийн хороо	Мөнгөн дүн
1	Аймгийн сонгуулийн хороо	12,283,200
2	Алтанбулаг сумын сонгуулийн хороо	309,000
3	Аргалант сумын сонгуулийн хороо	50,000
4	Архуст сумын сонгуулийн хороо	439,000
5	Батсүмбэр сумын сонгуулийн хороо	449,000
6	Баян сумын сонгуулийн хороо	455,600
7	Баяндэлгэр сумын сонгуулийн хороо	399,000
8	Баянжаргалан сумын сонгуулийн хороо	558,000
9	Баян-Өнжүүл сумын сонгуулийн хороо	173,000
10	Баянхангай сумын сонгуулийн хороо	133,000
11	Баянцагаан сумын сонгуулийн хороо	539,500
12	Баянцогт сумын сонгуулийн хороо	212,000
13	Баянчандмань сумын сонгуулийн хороо	67,000
14	Борнуур сумын сонгуулийн хороо	367,500
15	Бүрэн сумын сонгуулийн хороо	567,000
16	Дэлгэрхаан сумын сонгуулийн хороо	299,000
17	Жаргалант сумын сонгуулийн хороо	402,636
18	Заамар сумын сонгуулийн хороо	303,500
19	Зуунмод сумын сонгуулийн хороо	129,300
20	Лүн сумын сонгуулийн хороо	312,400
21	Сүмбэр сумын сонгуулийн хороо	196,000
22	Сэргэлэн сумын сонгуулийн хороо	210,000
23	Угтаал сумын сонгуулийн хороо	108,000
24	Цээл сумын сонгуулийн хороо	422,000
25	Эрдэнэ сумын сонгуулийн хороо	738,000
26	Эрдэнэсант сумын сонгуулийн хороо	325,000
	Дүн	20,447,636

Сонгуулийн хороодын сонгуулийн зардалын төсвөөс худалдан авсан 20447.6 мянган төгрөгийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох бусад эрхийн актын дагуу орлого авч аймаг, сумдын ЗДТГ-ын данс бүртгэлд тусган ашиглах шаардлагатай байна.

ССХорооны зардалын гүйцэтгэлд аудит хийхэд дараахь зөрчилүүд илэрлээ. Үүнд:

- Аргалант ССХороо санал авах байр бэлтгэх зардал, бичиг хэрэг, шуудан холбооны зардал, шатахууны зардал нийт 1954.0 мянган төгрөгийг иргэн Х.Бадамцэцэгийн хувийн харилцах дансанд шилжүүлж зарцуулсан. Мөн шатахууныг бэлэн мөнгөөр худалдан авсан.

- Аргалант, Баянчандмань сумдын СХороо бараа материалын тайлан гаргаагүй.

- Баянчандмань ССХороо зохион байгуулагч 47 хүнд 615.00 мянган төгрөгийн шуудан холбооны зардал олгосон баримтууд гарын үсэг зурагдаагүй.

•Баянжаргалан ССХороо холбооны зардал болох утасны нэгжийг сонгуулийн зохион байгуулагч нэг бүрт тараасан жагсаалт байхгүй

•Зуунмод ССХороо шатахууны зардал зарцуулахдаа явсан газрын маршрут байхгүйгээр км-ыг бөөн дүнгээр нь бичиж зарлагдсан байна.

АСХороо нь зардлын гүйцэтгэлийн тайлангаас гадна бараа материалын орлого, зарцуулалтын тайланг гаргасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн улсын төсвөөс санхүүжүүлэх зардалын гүйцэтгэл

Асуудал 2

Аймгийн сонгуулийн хороо сумдын сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтыг хүлээж авахдаа акт үйлдээгүй байна.

2.1. Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан эсэх.

АСХороо СЕХ-ны 2016 оны 4-р тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайланг гаргах тухай журам”-ын 2 дугаар хавсралтаар, ССХороод 3 дугаар хавсралтаар батлагдсан маягтаар сонгуулийн зардалын тайланг гаргасан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн эхний шатны санал хураалтаар Төв аймагт 379193.4 мянган төгрөг хувиарлагдаж 360285.6 мянган төгрөг зарцуулж 18907.8 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн. Зардлын зүйлүүдээс унааны зардал, сурталчилгааны зардал, сурталчилгааны материал хүргэх зардал, санал авах байр бэлтгэх зардалууд төсөвлөсөн хэмжээнд бүрэн зарцуулагдаж бусад зардалууд 5.5-6851.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Төв аймгийн СХорооны зардалын нэгдсэн тайлан /эхний шат/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сургалтын зардал	24,860,000	21,146,715	3,713,285
2	Тогтоол протокол хэвлүүлэх зардал	250,000	145,050	104,950
3	Бичиг хэргийн зардал	21,320,000	21,288,151	31,849
4	Шуудан холбооны зардал	19,970,000	19,905,310	64,690
5	Унааны зардал	38,000,000	38,000,000	-
6	Сурталчилгааны зардал	4,000,000	4,000,000	-
7	Сурталчилгааны материал хүргэх зардал	7,375,000	7,375,000	-
8	Санал авах байр бэлтгэх	16,800,000	16,799,995	5
9	Саналын хуудас хүргэх	7,171,000	4,245,000	2,926,000
10	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	13,012,000	6,161,000	6,851,000
11	Мэдээ дамжуулах зардал	4,425,000	4,419,500	5,500
12	Томилолтын зардал	5,782,000	4,577,450	1,204,550
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	3,528,000	3,520,000	8,000
14	Болзошгүй зардал	3,000,000		3,000,000
15	Сонгуулийн байгууллагын ажилтаны урамшуулал, хоолны зардал	179,156,000	178,188,000	968,000
16	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	30,544,400	30,514,400	30,000
17	Төвлөрүүлсэн үлдэгдэл		18,907,829	-18,907,829
	Нийт дүн	379,193,400	379,193,400	-

Хоёрдох шатны санал хураалтаар Төв аймагт 136085.0 мянган төгрөг хувиарлагдаж 128123.4 мянган төгрөг зарцуулж, 7961.6 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

Төв аймгийн СХорооны зардалын нэгдсэн тайлан /хоёрдох шат/

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сургалтын зардал			
2	Тогтоол протокол хэвлүүлэх зардал			
3	Бичиг хэргийн зардал	1,900,000	1,861,300	38,700
4	Шуудан холбооны зардал	2,320,000	2,320,000	-
5	Унааны зардал	5,125,000	5,125,000	-
6	Сурталчилгааны зардал			-
7	Сурталчилгааны материал хүргэх зардал			
8	Санал авах байр бэлтгэх			
9	Саналын хуудас хүргэх	7,171,000	5,216,000	1,955,000
10	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	13,296,000	8,299,450	4,996,550
11	Мэдээ дамжуулах зардал	4,425,000	4,322,000	103,000
12	Томилолтын зардал			-
13	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	3,528,000	3,299,600	228,400
14	Болзошгүй зардал			-
15	Сонгуулийн байгууллагын ажилтаны урамшуулал, хоолны зардал	82,000,000	81,400,000	600,000
16	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	16,320,000	16,280,000	40,000
17	Төвлөрүүлсэн үлдэгдэл		7,961,650	(7,961,650)
	Нийт дүн	136,085,000	136,085,000	-

Хоёрдох шатны санал хураалтад хувиарласан төсвөөс шуудан холбоо, унааны зардал төсөвлөсөн хэмжээнд зарцуулагдаж бусад зардалууд 38.7-4996.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

АСХороо нь холбогдох хууль тогтоомж, СЕХ-ны 2016 оны 4-р тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайланг гаргах тухай журам”, СЕХ-с ирүүлсэн зөвлөмж чиглэлийг баримтлан зардлын бүртгэлийг хөтлөн гүйцэтгэлийн тайлан гаргасан байна.

Харилцах дансны баримтуудыг холбогдох журмын дагуу, анхан шатны баримтыг тавигдах шаардлагын дагуу бүрдүүлэн, хавсаргаж эмх цэгцтэйгээр үдсэн байна. Зардлын зүйл гүйлгэж зарцуулаагүй, бараа материалын тайлан гаргаж ирүүлжээ.

Харин ССХороодын хувьд “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайланг гаргах тухай журам”-ын 4.3-д заасны дагуу зардлын тайлангийн бүрдүүлбэрийн байдлыг авч үзвэл:

Журмын 4.3.1-д заасан “сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичгийг” Алтанбулаг, Аргалант, Архуст, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Зуунмод, Лүн, Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэсант зэрэг сумд ирүүлээгүй,

Журмын 4.3.2-д заасан “тайлангийн товч танилцуулга, тодруулга”-ыг Алтанбулаг, Баян, Батсүмбэр, Баянчандмань, Дэлгэрхаан, Жаргалант, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сэргэлэн сумдаас бусад 18 сумд гаргаж ирүүлээгүй,

Журмын 4.3.4-д заасан “санхүүгийн анхан шатны баримтууд хүлээлгэн өгсөн акт”-г нэг ч сум үйлдээгүй байна.

Мөн түүнчлэн 17 сумдын СХороо харилцах дансны хуулга боловсруулалгүй зардлын гүйцэтгэлийн тайлан гаргажээ.

ССХорооны сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримтуудыг төрийн аудитын байгууллагад 2017 оны 7 дугаар сар 26-наас эхлэн ирүүлсэн бөгөөд 8 дугаар сарын 4-нд сүүлийн сумдын тайлан, баримтууд цуварч ирсэн. Цаашид дээрх журамд заасан хугацааг харгалзан АСХороо нь ССХорооны тайлан баримтуудыг хүлээж авч нэгтгэх, төрийн аудитын байгууллагад аудит хийлгэх

хугацааг тооцон сумдын тайлан, баримт ирүүлэх хугацааг тоогтоож өгч байх нь зүйтэй байна.

2.2. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт тавьж ажилласан эсэх

Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 04 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4-д “Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хорооны хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажилласан тухай ямар нэг тайлан мэдээлэл байхгүй байна.

Мөн дээрх журмын 4.6-д “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтын хамт архивын нэгж болгон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын архивт албан ёсоор хүлээлгэн өгнө” гэсэн заалт хэрэгжээгүй, ССХорооноос санхүүгийн анхан шатны баримтыг хүлээн авч акт үйлдээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

- Сонгуулийн Ерөнхий Хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангилалын дагуу нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгогчийн тоо болон сумын сонгуулийн хороо, санал авах байр, тэдгээрт ажиллах гишүүдийн тоог харгалзан хувиарлажээ.
- АСХороо нь ССХ-нд төсөв зардал хувиарлахдаа СЕХ-оос ирсэн албан тоотууд түүний хавсралт төсөв хувиарласан тайлбарт заасан чиглэл, зөвлөмжүүдийг баримтлан ажилласан байна.
- Аймаг сумдын сонгуулийн хороод сонгуулийн зардлын төсвөөс 20447.6 мянган төгрөгийн дахин ашиглах боломжтой эд хөрөнгө худалдан авчээ
- АСХороо нь холбогдох хууль тогтоомж, СЕХ-ны 2016 оны 4-р тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайланг гаргах тухай журам”, СЕХ-с ирүүлсэн зөвлөмж чиглэлийг баримтлан зардлын бүртгэлийг хөтлөн гүйцэтгэлийн тайлан гаргасан байна.
- Дээрх журмын 4.6-д заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн:

Аймгийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарт зөвлөх нь:

1. Аймаг, сумдын сонгуулийн хороодын худалдан авсан 20447.6 мянган төгрөгийн эд хөрөнгө, техник хэрэгслийг аймаг сумдын ЗДТГазарт шилжүүлэн өгч данс бүртгэлд тусгуулах
2. Сумдын сонгуулийн хорооны тайлан, анхан шатны баримтыг хүлээж авах хугацааг тогтоон сумдад мэдэгдэх, хүлээж авсан акт үйлдэж байх

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТОР

Ц.САРАНЧИМЭГ

АУДИТОР

О.СОСОР

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал


**ТӨВ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 7027 Факс: 7027.....

2017.08.10 № 107
танай _____-ны № _____-т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬАА ТӨВ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны
ээлжит сонгууль явуулахад зарцуулсан аймгийн
сонгуулийн хорооны зардлын нэгдсэн тайланд хийсэн
нийцлийн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

ДАРГА  Ч.САРАНГЭРЭЛ



0145

My.doc: TootA5-3/2017

